



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 07-ны өдөр

Дугаар 24/004

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.1.1, 46.1.2, 76-р зүйлийн 76.1.12, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийг 7.27, 7.31, “Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллаганы журам”-ын 8 дугаар зүйлийг 8.1, 8.2 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02-р сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 43 хувь буюу 103,356,372 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд тус бүр 3 төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашиг хуваарилах шийдвэрлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
5. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.
6. Ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД